

*Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны
төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалт,
үр дүн*



**“ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ-ХОТ ТӨЛӨВЛӨЛТ”-ИЙН
ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ
БАЙНА**

Агуулга	Товчилсон үгс	2
Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар	Аудитын зорилт, арга зүй, хамарсан хүрээ	3
<i>Газрын захирал:</i> <i>Д.Ганбилэг</i>	<u>Бүлэг 1</u> <i>Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийн биелэлт удааширсан байна</i>	4-6
<i>Аудитын менежер:</i> <i>Х.Баярмаа</i>	<i>Аж ахуйн нэгж байгууллагууд ажлаа гүйцэтгэсний дараа тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан байна</i>	7
<i>Шинжээч:</i> <i>Ц.Эрдэнэчулуун</i>	<i>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт удааширсан байна</i>	8
<i>М.Доржмаа</i>	<u>Бүлэг 2</u> <i>Орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэхгүй байна</i>	10
	<i>Төсвийн зарим зардлыг хэтрүүлжээ</i>	11
	<i>Өр авлага буурахгүй байна</i>	12
	<i>Ашиглалтад хүлээн авсан зарим хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, шаардлагагүй үнэт цаасыг данснаас хасаагүй байна</i>	12
Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.www.mnao.mn	<i>Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна</i>	12-13
<i>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261456 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<u>Бүлэг 3</u> <i>"Газар зохион байгуулалт-Хот төлөвлөлт"- ийн жилийн хүрээнд төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжээгүй байна</i>	14-15
	Дүгнэлт	16
	Зөвлөмж	17
	Холбогдох байгууллагын санал	
	Саналд өгөх тайлбар	
ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3, Засгийн газрын IV байр Улаанбаатар хот 15160 Монгол улс</i>		

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТБУСТ	Төрийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЗТБХБС	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын тамгын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ГХБГЗЗГ	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ССХОБЗА	Сургалт, сурталчилгаа, хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн алба
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
ТУХ	Төсөл удирдах хороо
ШУТЗ	Шинжлэх ухаан техникийн зөвлөл
ААН	Аж ахуйн нэгж



ГХБГЗЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ

ГХБГЗЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, улсын төсөв, зээл, тусламжаар санхүүжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийж дүнг УИХ-ын гишүүн, Барилга хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд болон холбогдох байгууллага, олон нийтэд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- ☐ ГХБГЗЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнтэй эсэх,
- ☐ Төсвийн болон үйл ажиллагааны орлого, зарлага, төрийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт үр дүнтэй эсэх,
- ☐ Улсын төсвийн болон зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитаар ГХБГЗЗГ-ын 2011 он, 2012 оны эхний хагас жилийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, улсын төсвийн болон зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг ЗТБХБЯ /хуучнаар/ болон тус газрын алба, хэлтэс, холбогдох байгууллагыг хамруулан шалгалаа.

ЗТБХБЯ-ны /хуучнаар/ хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээс БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”-ийн зарим бүрэлдэхүүн хэсэг нь ГХБГЗЗГ-т хамрагдаж байгаа боловч уг төслийг хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн бүтэц олон удаа өөрчлөгдсөн, хэрэгжүүлэгчийн хамрах хүрээ өргөн зэргээс шалтгаалж, төслийн явцыг бүрэн шалгах бололцоогүй байлаа.

Аудитын арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж асуулга, лавлагаа, тайлбар мэдээ гаргуулах, ажлын явц, хэрэгжилтийн талаар холбогдох материал, нотлох баримтыг гаргуулан судалж шалгуур үзүүлэлт, бодит байдалтай харьцуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглалаа.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитыг хянан баталгаажуулах журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

1.5 2011 онд ГХБГЗЗГ 67 бүтээгдэхүүн ажил үйлчилгээний хүрээнд 511 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 4 дүгээр улирлын байдлаар нийт ажлын гүйцэтгэл 66.1- 77.1 хувь байсан байна.

1.6 Ажлын хэрэгжилт дутуу байгаа нь үндсэн үйл ажиллагааг олон дэд хэсэг, жижиг арга хэмжээ болгон задалж, ингэснээр хоорондын уялдаа холбоо алдагдаж, ажил орхигдон, давхардал үүссэнээс шалтгаалжээ. Тухайлбал;

Техникийн бодлого, норм нормативын хэлтэс 7 бүтээгдэхүүний 19 үндсэн үйл ажиллагааг 120 дэд арга хэмжээний дагуу хэрэгжүүлж 4 дүгээр улирлын байдлаар ажлын гүйцэтгэл 72.7 хувьтай байна.

1.7 2012 онд газрын харилцаа, хот байгуулалтын албаны 6 хэлтсийн хүрээнд нийт 71 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг 296 арга хэмжээний дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 3 дугаар улирлын байдлаар нийт ажлын гүйцэтгэл 0-40.1 хувь байна. Үүнд;

№	Нийт ажил үйлчилгээ	Тоо	Хэрэгжилтийн хувь
1	Бүрэн хэрэгжсэн	41	14,4
2	Хугацаандаа хэрэгжиж байгаа	114	40,1
3	Хугацаа хоцорсон	114	40,1
4	Огт хэрэгжээгүй	25	8,5
5	Тендерийн шатанд	2	0

1.8 2012 онд хугацаа хоцорсон 114, хэрэгжээгүй тасарсан 25 арга хэмжээ байгаа нь өмнөх онд хэрэгжихгүй байхад нөлөөлсөн зөрчил дутагдал арилаагүйг харуулж байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хэлтэс тус бүрээр харуулбал;

№	Хэлтэсүүдийн нэр	Бүрэн хэрэгжсэн	Үргэлжилж байгаа	Хугацаа хоцорсон	Тасарсан	Хугацаа болоогүй	Нийт
1	Газрын кадастр	11	11	23	0		45
2	Орон зай, мэдээллийн технологи	1	9	22	13	2	47
3	Газар зохион байгуулалт газар өмчлөл	11	17	20	5	-	53
4	Геодези, зураг зүйн хэлтэс	14	29	44	5		92
5	Захиргаа, хяналт шинжилгээ	4	42	5	2	-	53
6	Санхүү аж ахуй	-	6	-	-	-	6
	Бүгд	41	114	114	25	2	296

Хэрэгжээгүй буюу хугацаа хоцорсон ажлуудыг дурдвал;

- Газрын харилцаа, барилга, орон сууц, хот байгуулалт, нийтийн аж ахуйн талаар стандарт, дүрэм журам, арга зүй норм заавруудыг боловсронгуй болгох;
- Нийслэлийн хэмжээнд гарч байгаа газрын зөрчил, маргааны талаарх судалгааг нарийвчлан гаргах, шалтгааныг ангилан тогтоох, зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ЗТБХБЯ-нд танилцуулах;
- Иргэнд гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүйгээр нэг удаа газар өмчлүүлэх шийдвэр гаргахад эрх бүхий Засаг даргыг мэдээллээр хангаж ажиллах;
- “2012 онд Монгол Улсын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршил зориулалт”-ыг баталсан Засгийн Газрын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах, иргэдэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэх;

- Төрөөс газрын талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах;
- Байгууллагын архивын баримт тоо бүртгэл үйлдэх, хадгалалт хамгаалалт, лавлагаа мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

1.9 Орон зай, мэдээллийн технологийн хэлтэс нийт 47 арга хэмжээ хэрэгжүүлэхээс хэрэгжээгүй тасарсан 13, хугацаа хоцорсон 22 ажил байгаа бөгөөд 2012 оны 3 дугаар улирлын байдлаар нийт ажлын гүйцэтгэл 0-20.0 хувьтай байна.

1.10 Тус хэлтэс “Барилгын материалын үйлдвэржилтийг дэмжих бодлого”, “Барилгын салбарын норм, нормативын мэдээллийн санг шинэчилж мэдээлэл оруулах”, “Нэг цэгийн үйлчилгээний ажлыг зохион байгуулах” зэрэг ажил үйлчилгээг барилга нийтийн аж ахуйн албаны хэлтэстэй хамтран хэрэгжүүлэх байжээ.

1.11 ГХБГЗЗГ 2011- 2012 оны үр дүнгийн гэрээ, бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөндөө Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажлуудыг тусган хэрхэн хэрэгжүүлснийг харуулбал;

Төлөвлөгөөт ажил	2011 он					2012 он /эхний хагас жил/				
	ТАХ ний тоо	Хэрэгжсэн				ТАХ ний тоо	Хэрэгжсэн			
		Тоо	Дутуу	Хувь	Хэрэгжих шатанд		Тоо	Дутуу	Хувь	Хэрэгжих шатанд
МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	17	14	-	82,4	3	7	3	-	42,8	4
МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр	29	22	2	75,8	5	29	27	-	93,1	2
ГХБГЗЗГ-ын бүтээгдэхүүн нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө	67	60	1	89,5	6	72	59	2	81,9	11

1.12 2012 оны эхний хагас жилийн байдлаар дээрх төлөвлөгөөт ажлуудын гүйцэтгэл 43-93.1 хувьтай байгаа ч сонгон шалгаруулалтын болон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж ажил эхлэх шатандаа байгаа төсөл, арга хэмжээ олон байна.Тухайлбал;

- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 7.11–т “Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцны хороолол болгон хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд хийгдэх “Зүүн хүрээ”, 4-р хорооллын “Баруун хүрээ” цогцолборуудын инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2012 оны 4 дүгээр сарын 17-нд нээх байсан ч тодорхойгүй хугацаагаар хойшилсон;
- Мөн шугам сүлжээний 3 багц ажлын тендер 2012 оны 6 дугаар сарын байдлаар үнэлгээний шатанд байсан;
- 2020 он хүртэл УБ хотын “Зүүн Сэлбэ”, “Цэргийн хотхон”, “Ханын материал орчим”, “Дэнжийн 1000”, МҮОНРТ орчим, VII, XIV хорооллуудад барилга байгууламжуудыг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөснөөс өөр ажил хийгдээгүй;
- Эдгээр ажлаас эхний ээлжинд буюу 2013 онд ашиглалтад орох МҮОНРТ орчим, VII, XIV хорооллын нийт ажлын гүйцэтгэл 2012 оны 4-р улирлын байдлаар 40 хувийн санхүүжилт авсан ч 27.7 хувийн ажлын гүйцэтгэлтэй, төлөвлөсөн ажлууд хугацаандаа хэрэгжих нь эргэлзээтэй;
- 3.9.5-д тусгагдсан “Цэвэр усны суурин болон зөөврийн лаборатори байгуулах” ажлын хүрээнд “Ундны болон бохир усны цэвэрлэгээний хяналтын суурин болон зөөврийн лабораторийг аймгийн төвүүдэд үе шаттайгаар байгуулж үйл ажиллагааг боловсронгуй болгох төслийг 2012-2017 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар 2012 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн албан бичгийг яаманд хүргүүлсэн байна.

Аж ахуйн нэгж байгууллагууд ажлаа гүйцэтгэсний дараа тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан байна

1.13 2011 он, 2012 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3876 аж ахуйн нэгжид барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил, материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ, нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулжээ.

№	Тусгайзөвшөөрлийнтөрөл	2011 он				2012 он			
		Өргөдөл ирүүлсэн	Сунгах	Нэмэлт	Шинэ	Өргөдөл ирүүлсэн	Сунгах	Нэмэлт	Шинэ
1	Зураг төсөл боловсруулах	345	70	60	215	306	25	36	245
2	Барилгын угсралтын ажил	1598	157	247	1194	1460	110	162	1188
3	Барилгын материалын үйлдвэрлэл	37	0	1	36	25	1	0	24
4	Өргөх байгууламж түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт асвар үйлчилгээ	13	6	0	7	40	1		39
5	Нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ	50	19	0	31	2	0	0	2
НИЙТ		2043	252	308	1483	1833	137	198	1498

1.14 2012 онд шаардлага хангаагүй 835 материал буцаагдсан байна. Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлт, бүрдүүлсэн материалыг судлахдаа тухайн компанийн өмнөх онуудад болон одоогийн үйл ажиллагааг нарийвчлан хянаагүйгээс ажил гүйцэтгэсний дараа зөвшөөрөл олгодог зөрчил байсаар байна. Тухайлбал;

- “Зэд прожект” ХХК 2011 онд ГХБГЗЗГ-т барилгын ажлын зураг, төсөв гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж 2012 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр гэрчилгээ авсан ч 2010 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр СБД-ийн 7-р хороололд 12 давхар 72 айлын орон сууцны 37,268.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий зураг төсөл боловсруулах ажлын гэрээ;
- 2010 оны 10 сарын 15-ний өдөр 7-р хороололд 12 давхар 144 айлын орон сууцны 61,260,0 сая төгрөгийн зураг төсөл боловсруулах ажлын гэрээг захиалагч байууллага болох “Бэрэн констракшн энд автомэшин” ХХК –тай байгуулж ажлаа гүйцэтгэжээ.

1.15 ГХБГЗЗГ 2011 оны 4 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөл шинээр авсан, сунгуулсан 1528 байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан байна.

1.16 Орон сууцны хороолол барих төсөл хөтөлбөрийн хүрээнд баригдах барилга байгууламжийн зураг төсөв, угсралтын ажлыг зөвшөөрөлгүй компани гүйцэтгэж байгаа нь Барилгын тухай хуулийн 16.6¹-т заасныг зөрчиж байна. Тухайлбал;

- “Бэрэн констракшн энд автомэшин” ХХК 2007 оны 4 дүгээр сарын 11-нээс 3 жилийн хугацаатай тусгай зөвшөөрөл авсан бөгөөд 2010 оны 4 дүгээр сард хүчинтэй байх хугацаа дууссан боловч дахин сунгаагүй байна. Тус компани Улаанбаатар хотын радио телевизийн орчим, 7-р хороололд 7408 айлын орон сууцны барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг ЗТБХБЯ-тай 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр байгуулснаар ажлаа эхэлж 2012 оны 2 дугаар сарын 3-ны өдөр барилга угсралтын ажил гүйцэтгэх зөвшөөрөл авах хүсэлтээ гаргажээ.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт удааширсан байна

¹“Барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр эхлэх, үргэлжлүүлэхийг хориглоно”

1.17 Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр 2003-2008 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүртэл иргэд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг хамтран өмчилж байсныг 2008 оноос Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх болсноор нийт **640249** иргэн **71656.84** га газрыг хувийн эзэмшилдээ өмчилж авсан нь улсын хэмжээнд бүртгэгдсэн иргэдийн 25 орчим хувь байгаа нь 9 жилийн хугацаанд хэрэгжиж байгаа тус арга хэмжээний хэрэгжилт удаашралтайг харуулж байна.

1.18 Дотоодын түүхий эдэд түшиглэн цемент, арматур, шилэн хийц, дулаан тусгаарлах материалын үйлдвэрүүдийн хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчин бүрдүүлэх ажил хийгдэхээс аймаг орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг хуванцар цонх хаалга, бетон хийц эдлэл, хүрмэн бетон, зам талбайн тохижилтын хавтан, элс хайрганы үйлдвэрийн технологийн зааврыг хянан баталгаажуулж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн байна.

1.19 Мөн 4 суманд байгуулах нийт 2400,0 мянган тн-ын хүчин чадалтай цементийн үйлдвэрийн ТЭЗҮ-г ЗТБХБЯ-ны ШУТЗ-д бичгээр хүргүүлснээс өөр барилгын голлох материалын үйлдвэрийг байгуулах чиглэлээр бодит ажил хийгдээгүй байна. Энэ нь чанартай барилгын материалыг өөрийн оронд үйлдвэрлэж, дотоодод хямд үнээр нийлүүлэх боломжийг бууруулж байна.

1.20 Хүн амын нутагшил, суурьшил, бүлэг суурингийн тогтолцооны төсөл зэрэг бодлогын баримт бичгүүдийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлснээр 562.0 сая төгрөг батлагдаж 1 дүгээр шатны зорилтот ажил хэрэгжжээ.

1.21 2015 он хүртэл “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах ажлын тендерийн үнэлгээний хороог байгуулж гүйцэтгэгч сонгон шалгаруулалт хойшлогджээ.

1.22 Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.3-т хүн амын нутагшил, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор “Хотууд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.23 Төслийг 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдөр УИХ-аар хэлэлцэж тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих ажлууд “Шинэ бүтээн байгуулалт”-ын зарим арга хэмжээтэй давхардсан тул тус хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болж батлагдсан байна.

1.24 Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрөөр баригдах барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулах ажилд тус агентлагаас мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэн, Радио телевиз хороолол, Сүхбаатар дүүргийн 7-р хороолол, Баянзүрх дүүргийн 14-р хороолол Эрдэнэт хотын 7а хорооллын эхний ээлжийн барилгуудын зураг төсөлд магадлал хийх мэргэжлийн экспертүүдтэй гэрээ байгуулан ажилласан байна. “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт тусгагдсан ажлын 2012 оны төлөвлөгөөт ажлын хэрэгжилт 30 хувьтай байна.

1.25 “100 мянган айлын орон сууц” төслийн хэрэгжилтийг санхүүжүүлэгч Хөгжлийн банкны хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүйгээс орон сууцыг иргэдэд зээлээр олгох ажил удааширсан, орон сууц барих газрыг чөлөөлөх хөрөнгийн эх үүсвэр хүрэлцэхгүй болжээ.



Төсвийн зарим зардлыг хэтрүүлэн зарцуулжээ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэхгүй байна

2.1 Тус газар 2011 онд өөрийн үйл ажиллагааны орлогоор 2965.1 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээс 3,020.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 55.2 сая төгрөг буюу 1.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

2.2 2012 оны эхний хагас жилийн байдлаар ГХБГЗЗГ, 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн газрын алба өөрийн орлогоор улсын төсөвт 1861.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 2040.9 сая төгрөгийг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөний биелэлтийг 179.7 сая төгрөг буюу 9.7 хувиар давуулан биелүүлжээ. Үүнд:

№	Орлогын төрөл	2011 он			2012 оны эхний хагас жил		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Ном, зураг, сэтгүүл гарын авлага	85.2	74.7	10.5			
2	Багаж баталгаажуулалт	59.0	59.8	(0.8)		37.4	
3	Газрын зургийн	19.0	6.9	12.1			
4	Үйлдвэр, үйлчилгээ, зөвшөөрөл, үнэлэлт,	0.6	0.8	(0.2)			
5	Экспертизийн	450.0	1, 145.2	(695.2)		534.4	
6	Норм нормативын сан	400.0	677.8	(277.8)		560.1	
7	Бусад орлого	67.4	26.8	40.6		48.9	
ГХБГЗЗГ-ын орлогын дүн		1081.1	1992.0	(910.9)	864.2	1180.8	(316.6)
1	Гэрчилгээний	500.0	507.5	(7.54)		367.6	
2	Газрын дуудлага худалдаа	148.4	188.1	(39.7)		160.0	
3	Кадастрын	72.0	64.0	7.0			
4	Хяналтын зардал / 2% /	1 161.6	259.1	902.5		323.9	
5	Хувийн хэргийн	1.0	2.3	(1.3)			
6	Бусад орлого	1.0	7.3	(6.3)		8.6	
Аймгийн орлогын дүн		1 884.0	1 028.3	855.7	997.0	860.1	136.9
Нийт дүн		2965.1	3020.3	(55.2)	1861.2	2040.9	(179.7)

2.3 2011 оны дүнгээр аймгийн ГХБХБГ, нийслэлийн газрын алба өөрийн орлогоор улсын төсөвт 1884.0 сая төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1028.3 сая төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 855.7 са төгрөгөөр тасалж, 2012 оны эхний хагас жилд 997.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 860.1 сая төгрөг төвлөрүүлж орлогыг 136.9 сая төгрөгөөр тасалсан дүнтэй байна.

2.4 2011 онд барилгын захиалагчийн хяналтын орлогыг **902.5** сая төгрөгөөр тасалсан нь нийт орлого буурахад нөлөөлсөн байна.

- Барилгын захиалагчийн хяналтын зардлын 2 хувийн орлого, орлогын төлөвлөгөөнд батлагдсан боловч аймаг, нийслэлийн төрийн сан, ЗДТГ-ын дансанд төвлөрүүлэн орон нутагт шууд зарцуулсан;
- Хуучин мөрдөж байсан үйлчилгээний орлого тооцох журмыг хүчингүй болгож, ЗТБХБС-ын 2009 оны 301 дүгээр тушаалаар “Барилгын тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлс тогтоох тухай журам” шинээр батлагдан мөрдсөн ч орлогыг хуучин журмаар батлуулсантай холбоотой байна.

2.5 ГХБГЗЗГ-ын 2011 оны орлогын 57.5 хувийг экспертизийн, 34.0 хувийг норм, нормативын сангийн орлого, 2012 оны эхний хагас жилийн орлогын 45.3 хувийг экспертизийн, 47.4 хувийг норм, нормативын сангийн орлого тус тус эзэлж байна.

2.6 Барилгын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу тус газар норм, нормативын санд 2011 онд 677.8 сая төгрөг, 2012 оны эхний хагас жилд 560.1 сая төгрөг, нийт 1237.9 сая төгрөг төвлөрүүлжээ.

2.7 ЗТБХБС-ын баталсан “Зураг төсөл, хайгуул судалгааны ажилд улсын экспертиз хийх, экспертүүдийг шалгаруулах, түүний ажиллах журам”-ын 6.2-т заасны дагуу зураг төсөлд магадлал хийсний орлого 2011 онд 1145.2 сая төгрөг, 2012 оны эхний хагас жилд 615.7 сая төгрөг, нийт 1760.9 сая төгрөгийг хуримтлуулан 739.2 сая төгрөгийг экспертизийн дүгнэлт гаргахад оролцсон орон тооны бус экспертүүдийн цалин, ажлын хөлсөнд зарцуулжээ.

2.8 Төсвийн орлогын төвлөрүүлэлтийн хувийн жинг авч үзвэл, 2011 онд төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын 65,9 хувь буюу 1,992.0 сая төгрөг нь ГХБГЗЗГ-ын, 34.0 хувь буюу 1,028.3 сая төгрөг нь аймаг нийслэл, дүүргийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, газрын албаны орлого эзэлж байна.

Төсвийн зарим зардлыг хэтрүүлжээ

2.9 ГХБГЗЗГ-ын системийн хэмжээгээр 2011 онд 9,778.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9,188.1 сая төгрөг зарцуулж, 590.8 сая төгрөгөөр, 2012 оны эхний хагас жилд 5,783.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 4,930.3 сая төгрөг зарцуулж, 853.6 сая төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэн ч зарим зардлын зүйл ангийг хэтрүүлэн зарцуулсан байна. Хэтэрсэн зардлыг хүснэгтээр харуулбал:

№	Зардлын төрөл	2011 он		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Бичиг хэргийн зардал	70.3	73.0	2.7
2	Тээвэр шатахууны зардал	142.4	144.9	2.5
3	Шуудан холбооны зардал	43.1	45.8	2.7
4	Эд хогшил худалдан авах зардал	7.1	8.4	1.3
5	Урсгал засварын зардал	18.3	150.6	132.3
6	Нэг удаагийн буцалтгүй тусламж	66.0	78.6	12.6
7	Төлбөр хураамж бусад зардал	69.1	425.7	356.6
8	Тэтгэврийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж	86.4	87.4	1.0
	Дүн	502.8	1014.4	511.6

/сая төгрөг /

2.10 Барилга байгууламжийн ашиглалт, норм, нормативын баримт бичиг, бүртгэл мэдээлэл боловсруулах, шинэчлэх талаар 2011 онд 57, 2012 оны эхний хагаст 48, нийт 105 байгууллага, аж ахуйн нэгж иргэдтэй гэрээ байгуулжээ.

2.11 Гэрээний үүргийг хангуулан, ажлын гүйцэтгэлд хяналт тавьснаар, үе шатны санхүүжилтэд 1,568.0 сая төгрөгийг олгож, техник хяналтын зардалд 73.4 сая төгрөг суутган, гэрээний үүргээ биелүүлээгүй 22 байгууллага, аж ахуйн нэгжид 4.8 сая төгрөгийн алданги тооцож төсвийн орлого болгосон байна.

2.12 2011 он, 2012 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 268 зөвшөөрөлтэй эксперт магадлагаа хийж, тэдгээрийн ажлын хөлсөнд 533.7 сая төгрөг олгожээ.

Өр авлага буурахгүй байна

2.13 2011 онд авлага өнгөрсөн оноос 31.5 сая төгрөгөөр, өглөг 135.5 сая төгрөгөөр, 2012 оны эхний хагас жилд авлага 257.8 сая төгрөгөөр, өглөг 209.5 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт өссөн авлагын 80 хувийг бараа, ажил үйлчилгээ худалдан авахтай холбогдон урьдчилан гарсан авлага эзэлж байна. Үүнд:

Д /д	Ангилал	2011 он			2012 оны эхний хагас		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн /- /Буурсан /+ /	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн/- Буурсан /+ /
1	Төлбөрт үйлчилгээний авлага	25,083.1	19,015.1	6,68.0	19,015.1	18,555.1	460.0
2	Байгууллагаас авах авлага	76,813.8	77,594.6	(780.9)	77,594.6	113.4	(35,842.6)
3	Хүмүүсээс авах авлага	9,228.7	9,098.4	130.4	9,098.4	27,945.2	(18,846.9)
4	Урьдчилж гарсан зардал	245,405.5	282,324.5	(36,919.1)	282,324.5	485,861.0	(203,536.4)
Авлагын дүн		356,531.1	388,032.6	(31,501.5)	388,032.6	645,798.6	(257,766.0)
1	Бараа үйлчилгээ	151,698.3	61,062.4	90,635.9	61,062.4	22,770.1	38,292.4
2	Байгууллагад өгөх өглөг	59,053.6	64,638.8	(5,585.2)	64,638.8	46,021.7	18,617.1
3	Хүмүүст өгөх өглөг	7,146.4	53,691.3	(46,544.9)	53,691.3	6,856.8	46,834.5
4	Урьдчилж орсон орлого	459,975.9	633,807.6	(173,831.6)	633,807.6	947,047.5	(313,240.0)
Өглөгийн дүн		677,874.3	813,200.1	(135,325.8)	813,200.1	1,022,696.1	(209,496.0)

Ашиглалтад хүлээн авсан зарим хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, шаардлагагүй үнэт цаасыг данснаас хасаагүй байна

2.14 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж ашиглалтад хүлээн авсан хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, 7 төрлийн үнэт цаас ашиглагдахгүй хадаглагдаж байна.

- Нийслэлийн газрын албанд 4, Дархан-Уул, Орхон, Булган аймгийн ГХБХБГ-т тус бүр 1, нийт 7 ш 258.0 сая төгрөгийн, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Хөвсгөл аймгийн ГХБХБГ-т нийт 12 ширхэг 408,0 сая төгрөгийн өртөг бүхий TRIMLE фирмийн NeTR9 загварын GPS, GNSS-ийн байнгын ажиллагаатай станц суурилуулсныг нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэж, тайлан тэнцэлд тусгаагүй;
- Үнэт цаасны үлдэгдлийг тулган баталгаажуулах тооллогоор 7 төрлийн 20,8 сая төгрөгийн ААН, иргэдийн газар өмчлөлийн эрхийн бичиг, дуудлага худалдааны тасалбарууд олон жил ашиглагдахгүй үлдээгдсээр бүртгэгдсээр байна.

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна

2.15 Аудитын явцад барилгын норм, норматив боловсруулах сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрч байна.

- ГХБГЗЗГ-ын даргын 2011 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 524 дүгээр тушаалаар Инженер архитектурын сургуульд “Барилгын норм, норматив боловсруулах сан”-гийн орлогоос 51.5 сая төгрөгийг хандивласан нь Барилгын тухай хуулийн 23.2²-т заасныг зөрчсөн;
- ГХБГЗЗГ-ын даргын 2011 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 582 дугаар тушаалаар Бүгд Найрамдах Турк Улсын барилгын салбарын төсөв, үнэ бүрдэлтийн норм, норматив боловсруулах үйл ажиллагаатай танилцаж туршлага судлах 15 ажилтны томилолтын нийт зардлын 57.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл 1.9 сая төгрөг;
- ГХБГЗЗГ-ын даргын 2011 оны 12 дугаар сарын 16-ны 599 дүгээр тушаалаар Европын холбооны барилгын норм, стандартуудыг нэвтрүүлэх үйл ажиллагааны концепцийг бодит болгох зорилгоор ХБНГУ, Польш, Литва зэрэг орнуудын барилгын салбарын норм, стандартыг боловсруулах ажилтай танилцах, “шаардлагатай эх материал бэлтгэх, холбогдох баримт бичиг тооцооны программ хангамж худалдан авах” 13 ажилтны томилолтын нийт зардлын 95.8 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэл 19.5 сая төгрөг нийт 21.5 сая төгрөгийг ажилчдын цалинд зарцуулж буцаан төвлөрүүлээгүй байна.

2.16 Аудитын явцад байгууллагын үйл ажиллагааны талаар газар, хэлтсүүдийн удирдлага, мэргэжилтнүүдээс авсан санал, асуулгын дүнг харуулбал;

Сэдэв	Санал асуулага	Үнэлгээ					
		Сайн		Дунд		Муу	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%
ГХБГЗЗГ-ын үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилт	Үйл ажиллагааны стратеги төлөвлөлт оновчтой эсэх	29	67,4	12	27,9	2	4,7
	Үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа талаар	24	55,8	18	41,9	1	2,3
	Үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих дотоод хяналтын үр нөлөө үр, дүнгийн талаар	26	60,5	14	32,6	3	6,9
Төсвийн болон үйл ажиллагааны орлого зарлага, төрийн өмчийн ашиглалт, хамгаалалт, үр дүн	Төсвийн болон үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн	30	69,8	13	30,2	-	-
	Зардлыг батлагдсан тариф, норм нормативын дагуу төлөвлөсөн эсэх, зарцуулалтын үр дүн	41	95,3	2	4,7	-	-
	Төсвийн болон үйл ажиллагааны орлого зарлагыг нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэсэн	42	97,7	1	2,3	-	-
	Хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, хамгаалалтад тавих хяналтын хэрэгжилт	40	93	3	2,3	-	-
	Дундаж үнэлгээ	-	77,1	-	20,9	-	2,0

2.17 Санал асуулгын дүнгээс үзэхэд, нийт оролцогчдын 77.1 хувь нь “Сайн”, 20.9 хувь нь “Дунд”, 2.0 хувь нь “Муу” гэсэн хариулт өгсөн байна.

²Барилгын норм, нормативийг боловсруулах сангийн хөрөнгийг норм, нормативын баримт бичгийг боловсруулах, шинэчлэх зорилгоор хэрэгжүүлнэ



Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн жилийн төлөвлөгөөт ажил хэрэгжээгүй байна

ГУРАВДУГААР БҮЛЭГ

"Газар зохион байгуулалт-Хот төлөвлөлт"-ийн жилийн хүрээнд төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжээгүй байна

3.1 2011 онд ГХБГЗЗГ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2,970.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дараах 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.



3.2 Дээрх 7 төсөл арга хэмжээнээс хугацаандаа дууссан 3, үргэлжлэн хэрэгжиж байгаа 4 ажил байна.

3.3 “Монгол Улсын иргэн бүрт өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил зориулалтыг тогтоож газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах” төсөл арга хэмжээг 2011-2012 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч тендер шалгаруулалт хүчингүй болж дахин зарлагдсанаар 2012 оны 3 дугаар улирлын байдлаар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн нь он дамжин хугацаа хоцорч хэрэгжихээр байна.

3.4 2012 онд тус газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 6,891,7 саятөгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл арга хэмжээг 2,642.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсвийн тодотголоор баталсан байна.

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг
1	GPS-ийн байнгын ажиглалтын станц	2012-2013	240.0
2	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудыг түшиглэн хөгжих хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах	2012-2016	1,740.0
3	Аймаг сум суурингуудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидргеологи газар хөдлөл техникийн судалгааны ажил	2012-2013	3.000.0
4	Гашуунсухайт, Шивээхүрэн, Бичигт, Булган, Бургастай, Ханги, Зэлтэр, Ханх, зэрэг боомтуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах	2012-2013	2.000.0
5	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол хийх	2012-2013	650.0
6	Дүүрэг аймгуудын газрын албадын барилгын засвар шинэчлэл	2012	500.0
7	Аймаг дүүргийн газрын албадын барилгын их засвар	2012	1.000.0
8	МУ-ын хүн ам нутагшил суурьшлын хөгжлийн төсөл	2012	9.100,0

3.5 Дээрх 8 төсөл арга хэмжээнээс хугацаандаа хэрэгжсэн 2, үргэлжилж байгаа 6 ажил байна.

3.6 “Монгол Улсын хүн ам нутагшил суурьшлын хөгжлийн төсөл” арга хэмжээг 2012 оны төсвийн тодотголоор хасагдсан байна.

3.7 ГХБГЗЗГ-т гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2 төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд;

3.8 МУЗГ, ХБНГУ хоорондын техникийн хамтын ажиллагаа, АНУ-ын Үндэсний орон зайн тагнуулын агентлагийн буцалтгүй тусламжаар “Газрын менежмент санхүүгийн кадастр”, “Өндөр нарийвчлалын сансрын зураг ашиглан байр зүйн зураг зохиох” төслүүд хэрэгжиж байна.

3.9 Гадаадын хандивлагч байгууллагуудын тусламжаар дээрх төслүүд хэрэгжсэнээр газрын харилцааны хууль эрх зүйн орчин сайжирч манай улсад газрын бодит үнэлгээ бий болох, энэ чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэгдэж, газартай холбогдон үүсдэг хүндрэл бэрхшээлүүд арилна гэж тооцжээ.

3.10 Байр зүйн зураглал зохиох ажилд АНУ-ын стандартыг нэвтрүүлснээр Алтанбулаг, Замын-Үүдийн чөлөөт бүс, Хөшгийн хөндийд баригдах олон улсын нисэх онгоцны буудал, Сайншандын аж үйлдвэрийн паркийг хамарсан газрууд өндөр нарийвчлалын зургаар хангагдахаар байна.

3.11 ЗТБХБЯ-ны /хуучнаар/ хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдээс БНХАУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Улаанбаатар хотын VII, XIV, МҮОНРТ-ийн хорооллын орон сууц, дэд бүтцийн төсөл”-ийн зарим бүрэлдэхүүн хэсэг нь ГХБГЗЗГ-т хамрагдаж байгаа болно.

3.12 Төслийг 2011-2013 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар ажлын гүйцэтгэл 27.7 хувь, санхүүжилт 40.0 хувьтай байна.



Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, дүн шинжилгээний үр дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

- ☐ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу төв суурин болон орон нутагт, шинээр суурьшлын бүс үүсгэхээр төлөвлөн иргэдэд өмчлүүлэхээр шийдвэрлэж хэмжээ, байршлыг нь тодорхойлсон газрын бодит үнэлэмж доогуур мөн иргэд оршин суух хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байгаа нь хувьдаа газар өмчлөх хүсэлттэй иргэдийн тоог бууруулж байна.
- ☐ Энэ нь газар ашиглалтыг сайжруулж, газрын шинэтгэлийг эрчимжүүлэх зорилгоор Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Монгол Улсын иргэнд нэг удаа үнэгүй газар олгох ажлын биелэлт удааширахад нөлөөлж байна.
- ☐ Агентлагийн чиг үүрэгт тусгагдсан тусгай зөвшөөрөл олгох ажлын зохион байгуулалт хангалтгүй, хяналт сул байгаагаас, барилга угсралтын ажил гүйцэтгэх зөвшөөрөлгүй компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.
- ☐ Агентлагтай гэрээ байгуулан ажиллаж байгаа орон тооны бус экспертүүд тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжийн хийсэн барилгын зураг, төсөвт магадлал хийж дүгнэлт гаргасан байна.
- ☐ Үйл ажиллагааны орлогыг үндэслэл муутай төлөвлөсөн, ТБУСТХ-ийн 5.1.4-т “Санхүү төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйгээс өр авлага буураагүй байна.
- ☐ Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо сул байгаагаас ГХБГЗЗГ болон нийслэл, дүүрэг, аймгуудын геодези зураг зүйн газрын албадын санхүү, аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдлууд гарсаар байна.
- ☐ Энэ нь норм, нормативын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, төслийн хөрөнгөөр санхүүжүүлж ашиглалтад хүлээн авсан хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн дансанд бүрэн бүртгээгүй байна.
- ☐ Үнэт цаасны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 7 төрлийн 20.8 сая төгрөгийн ААН, иргэдийн газар өмчлөлийн эрхийн бичиг, дуудлага худалдааны тасалбарууд олон жил ашиглагдахгүй үлдэгдэлтэй байна.



Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хүрэлшагайд

- ☐ Иргэдэд өмчлүүлэхээр шийдвэрлэсэн газарт төв суурингийн бүс үүсгэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний талаар болон тухайн газар нутгийн онцлогийг харуулсан мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж байх
- ☐ Газрын харилцааны тухай хууль эрх зүйн орчинг сайжруулах, газрын бодит үнэлгээг бий болгох чиглэлээр хэрэгжүүлсэн “Газрын менежмент санхүүгийн кадастр” төслийн үр ашгийг дээшлүүлэх
- ☐ Улсын чанартай авто зам болон шинээр тавигдах замын дагуу иргэдэд газар өмчлүүлэх боломжийг бүрдүүлэх, энэ чиглэлийн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх
- ☐ Барилга байгууламжийн зураг төслийн иж бүрдэл, магадлалын чанар, тусгай зөвшөөрөл олгох ажлын зохион байгуулалтад тавих хяналтыг сайжруулах
- ☐ Үйл ажиллагааны орлогыг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төсөв, норм, нормативын сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, жил дараалан өр, авлага нэмэгдэж байгаад дүгнэлт хийж, бууруулах арга хэмжээ авах
- ☐ Дотоод хяналтыг сайжруулах, аймаг, нийслэл, дүүргийн газрын албадын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3, Утас: 26-36-76,
Факс: (976-11) 32-26-83, E-mail: alagac@mongol.net

2012.12.27 № 1/326

танай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Тус газрын 2011-2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийгдсэн аудитийн дүгнэлттэй танилцлаа.

Бид дүгнэлт, зөвлөмжийн талаар ямар нэг саналгүй бөгөөд цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



А.ХҮРЭЛШАГАЙ

09 000462



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, улсын төсөв, зээл, тусламжаар санхүүжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалт үр дүнд"-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Барилга, хот, байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Хүрэлшагай нарт хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал (Б.Баттуяад) -д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

tushaal

070006